

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХОРШООДЫН 2011 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2011.11.14

Улаанбаатар хот


### НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 1 хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй<sup>1</sup> болгож, 10 хоршооны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэснээр 2011 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 170 хоршоо Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос 149 буюу нийт хоршоодын 87.64 хувь нь зохих журмын дагуу 2011 оны гуравдугаар улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн, 21 буюу 12.35 хувь нь ирүүлбэл зохих тайлан мэдээг хугацаанд нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй (үүнээс 13 буюу 61.9 хувь нь франчайзын гэрээтэй хоршоод) бөгөөд тус хоршоодын Хороонд ирүүлсэн хамгийн сүүлийн улирлын санхүүгийн тайлангаар нэгтгэлд хамруулсан болно.

Санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа ирүүлсэн 149 хоршооны тайлан мэдээг ирүүлсэн хугацаагаар нь авч үзвэл журмын дагуу хугацаандаа ирүүлсэн 67 хоршоо, 10 хүртэл хоног хугацаа хоцроосон 60 хоршоо, 11-ээс дээш хоног хугацаа хоцроосон 22 хоршоо байна.


Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдаж байгаа байдлыг харуулбал дараах байдалтай байна.<sup>2</sup>



<sup>1</sup> Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн **14.1.4** /тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн/, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн **25.1.8** /тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжийг ноцтой буюу удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хичингүй болгох талаар Хороонд санал оруулах/.

<sup>2</sup> Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын хяналт зохицуулалт, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх, үүрэг Хороонд шилжсэнээр тэдгээрийн санхүүгийн тайланг Хороонд хүлээн авч нэгтгэн, статистик мэдээ, тайлан нэгтгэлд хамрагдах болсон.

Хоршоодын гишүүдийн тоог графикаар үзүүлбэл:



Хорооны хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Онууд	шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	түдгэлзүүлснийг сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	Хоршоодын тоо
2006	51	0	0	-	-	51
2007	128	0	0	-	-	179
2008	45	15	5	-	-	209
2009	15	12	8	1	25	212
2010	2	35	15	4	80	179
2011-1	2	3	2	-	18	178
2011-2	0	7	2	-	12	171
2011-3	0	1	0	-	10	170

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 2.1 Нэгдсэн үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны III улирал	2010 оны III улирал
1	Хоршоодын тоо	170	184
2	Гишүүдийн тоо	26,969	25,465
3	Нийт актив /мян.төг/	59,360,797.6	46,938,581.4
	Банкны салбарт эзлэх хувь	0.9%	0.9%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	45,245,595.7	37,192,079.6
	Банкны салбарт эзлэх хувь	1.2%	1.2%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	3,035,489.5	3,848,762.3
	Банкны салбарт эзлэх хувь	0.8%	0.9%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	42,115,588.1	31,932,912.2
	Банкны салбарт эзлэх хувь	1.4%	1.5%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл /мян.төг/	8,192,257.4	7,291,187.8

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 2011 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

	Банкны салбарт эзлэх хувь	3.2%	3.0%
8	Өөрийн хөрөнгө /мян.төг/	12,016,243.0	11,724,523.6
	Банкны салбарт эзлэх хувь	2.9%	4.1%
9	Хоршоологчдын өмч /мян.төг/	3,823,985.6	3,764,880.8
10	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	1,715,090.9	643,385.8
11	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	272,126.3	252,473.9
12	Нийт орлого /мян.төг/	9,318,841.3	9,100,514.2
13	Нийт зардал /мян.төг/	8,290,565.4	8,537,139.3
14	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	1,028,275.9	563,374.9
15	Активын өгөөж /ROA/	2.3 %	1.7%

2011 оны гуравдугаар улиралд нийт 170 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хоршоодын байршлыг үзүүлвэл:



Тайлант улиралд 170 хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хоршоодоос Улаанбаатар хотод 73 хоршоо, орон нутагт 97 хоршоо үйл ажиллагаагаа явуулж байна.

**2.2 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд**

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны III улирал
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо	73
2	Гишүүдийн тоо	11,510
	Хоршооны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	19.75%
3	Нийт актив /мян.төг/	51,413,664.3
	Хоршооны нийт активт эзлэх хувь	86.61%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	38,773,118.9
	Хоршооны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	85.69%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	2,423,013.8
	Хоршооны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	79.82%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	38,423,365.0
	Хоршооны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	91.23%

7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	5,720,951.3
	Хоршооны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	69.83%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	3,056,539.8
	Хоршооны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	79.93%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	1,305,000.0
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	10,915.4
11	Нийт орлого /мян.төг/	7,648,837.1
12	Нийт зардал /мян.төг/	7,063,304.3
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	585,532.7

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 73 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 42.9 хувийг, тэдгээрийн нийт актив 51,413,664.3 мянган төгрөг байгаа нь нийт активын 86.6 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 73 хоршоо нь 7,648,837.1 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 82.1 хувийг, харин 7,063,304.3 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 85.2 хувийг тус тус эзэлж байна.

### 2.3 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2011 оны III улирал
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо	97
2	Гишүүдийн тоо	15,459
	Хоршооны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	28.96%
3	Нийт актив /мян.төг/	7,947,133.3
	Хоршооны нийт активт эзлэх хувь	13.38%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	6,472,476.8
	Хоршооны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	14.30%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	612,475.7
	Хоршооны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	20.18%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	3,692,223.0
	Хоршооны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	8.76%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	2,471,306.2
	Хоршооны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	30.16%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	767,445.7
	Хоршооны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	20.07%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	410,090.9
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	261,210.8
11	Нийт орлого /мян.төг/	1,670,004.2
12	Нийт зардал /мян.төг/	1,227,261.1
13	Тухайн үеийн ашиг /мян.төг/	442,743.1

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 97 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 57.0 хувийг, тэдгээрийн нийт актив 7,947,133.3 мянган төгрөг байгаа нь нийт активын 13.38 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 97 хоршоо нь 1,670,004.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 17.9 хувийг, харин 1,227,261.1 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 14.8 хувийг тус тус эзэлж байна.



Торгуулийн орлого	539.8	0.0%	-	0.0%	539.8	
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	2,150.3	0.0%	20,775.8	0.2%	- 18,625.5	-89.7%
ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	10,000.0	0.1%	-	0.0%	10,000.0	0.0%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	122,786.1	1.3%	562,282.6	6.2%	- 439,496.4	-78.2%
Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	54,365.4	0.6%	22,187.3	0.2%	32,178.1	145.0%
Бусад орлого	58,156.9	0.6%	112,243.7	1.2%	- 54,086.9	-48.2%
Онцгой шинжтэй орлого	13,371.0	0.1%	49,018.9	0.5%	- 35,647.9	-72.7%
Ердийн бус орлого	2.2	0.0%	83.2	0.0%	- 81.1	-97.4%
<b>Нийт орлогын дүн</b>	<b>9,318,841.3</b>	<b>100.0%</b>	<b>9,100,514.2</b>	<b>100.0%</b>	<b>218,327.1</b>	<b>2.4%</b>

Тайлант улиралд нийт орлогын 92.4 хувийг зээлийн хүүгийн орлого, 4.8 хувийг үйл ажиллагааны бусад орлого буюу хураамж, гишүүний татвар, үйлчилгээний хураамжийн орлого, 2.8 хувийг үйл ажиллагааны бус буюу торгуулийн орлого, үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого, гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого эзэлж байна.

### 3.2 Зардлын үзүүлэлтүүд

Тайлант улиралд нийт зардлын хэмжээ 8,290,565.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 246,573.8 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан нь үйл ажиллагааны бусад зардал 724,163., мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Зардал дараах бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.09.30		2010.09.30		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
<b>ХҮҮГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,450,620.5</b>	<b>65.8%</b>	<b>4,719,053.7</b>	<b>49.7%</b>	<b>731,566.7</b>	<b>15.5%</b>
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	3,059,577.6	36.9%	1,935,875.7	22.7%	1,123,701.8	58.0%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүртэлх хугацаатай)	2,099,475.3	25.3%	2,173,448.3	25.5%	- 73,973.0	-3.4%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жилийн хугацаатай)	166,900.2	2.0%	455,988.8	5.3%	- 289,088.6	-63.4%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	90,227.4	1.1%	113,915.5	1.3%	- 23,688.1	-20.8%
Бусад хүүгийн зардал	34,440.0	0.4%	39,825.4	0.5%	- 5,385.4	-13.5%
<b>БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>626,601.0</b>	<b>7.6%</b>	<b>1,080,332.8</b>	<b>49.7%</b>	<b>- 453,731.9</b>	<b>-42.0%</b>
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	597,317.6	7.2%	1,037,355.3	12.2%	- 440,037.8	-42.4%
Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	9,657.0	0.1%	2,031.2	0.0%	7,625.8	375.4%
Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	5,249.6	0.1%	40,388.6	0.5%	- 35,139.0	0
Бусад эрсдэлийн зардал	14,376.8	0.2%	557.7	0.0%	13,819.0	2477.7%
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>1,859,973.4</b>	<b>22.4%</b>	<b>1,661,638.7</b>	<b>19.5%</b>	<b>198,334.7</b>	<b>11.9%</b>
Боловсон хүчний зардал	1,178,604.0	14.2%	981,397.3	11.5%	197,206.7	20.1%
Бусад зардал	681,369.4	8.2%	680,241.4	8.0%	1,128.0	0.2%
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>353,370.6</b>	<b>4.3%</b>	<b>1,076,113.9</b>	<b>12.6%</b>	<b>- 722,743.3</b>	<b>-67.2%</b>
Торгуулийн зардал	5,933.4	0.1%	9,184.2	0.1%	- 3,250.8	-35.4%
Ногдол ашгийн зардал	1,420.0	0.0%	-	0.0%	1,420.0	
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	297.0	0.0%	3,051.1	0.0%	-	-90.3%
					2,754.1	
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	160,152.2	1.9%	872,403.1	10.2%	-	-81.6%
					712,250.9	
Үйл ажиллагааны бус бусад зардал	11,869.9	0.1%	45,210.1	0.5%	-	-73.7%
					33,340.3	
Ердийн бус зардал	1,094.3	0.0%	286.7	0.0%	807.7	281.7%

Татварын зардал	172,603.7	2.1%	145,978.6	1.7%	26,625.1	18.2%
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>8,290,565.4</b>	<b>100.0%</b>	<b>8,537,139.2</b>	<b>100.0%</b>	<b>-246,573.86</b>	<b>100.0%</b>

Нийт зардлын 65.7 хувийг хүүгийн зардал, 7.6 хувийг болзошгүй эрсдэлийн сангийн зардал, 22.4 хувийг үйл ажиллагааны зардал, 2.2 хувийг үйл ажиллагааны бус зардал тус тус эзэлж байна.

Тайлант хугацааны цэвэр ашгийг үзүүлвэл:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.09.30		2010.09.30		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Нийт орлогын дүн	9,318,841.32		9,100,514.19		615,948.11	
<b>Нийт зардлын дүн</b>	<b>8,290,565.43</b>		<b>8,537,139.29</b>		<b>-246,573.86</b>	
<b>Ашиг</b>	<b>1,028,275.89</b>		<b>563,374.90</b>		<b>464,900.99</b>	

## ДӨРӨВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

### 4.1 Активын чанар

Хоршоодын тайлант улирлын нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:


/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.09.30		2010.09.30		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	58,019,966.8	97.7%	45,861,095.5	97.7%	12,158,871.3	26.5%
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>11,520,849.8</b>	<b>19.4%</b>	<b>7,279,768.7</b>	<b>15.5%</b>	<b>4,241,081.1</b>	<b>58.3%</b>
1.Касс дахь бэлэн мөнгө	1,843,477.6	3.1%	1,299,466.1	2.8%	544,011.5	41.9%
2.Банкинд байршуулсан харилцах	5,756,601.5	9.7%	3,450,609.2	7.4%	2,305,992.4	66.8%
3.Банкинд байршуулсан хадгаламж	3,920,179.4	6.6%	2,529,693.4	5.4%	1,390,486.0	55.0%
4.Бусад байгууллагад байршуулсан харилцах	569.8	0.0%	-	0.0%	569.8	0.0%
5.Бусад байгууллагад байршуулсан хадгаламж	21.5	0.0%	-	0.0%	21.5	0.0%
<b>ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)</b>	<b>42,954,608.3</b>	<b>72.4%</b>	<b>34,629,368.1</b>	<b>73.8%</b>	<b>8,325,240.2</b>	<b>24.0%</b>
8. Нийт зээл	45,245,595.7	76.2%	37,192,079.6	79.2%	8,053,516.1	21.7%
8.1.Хэвийн зээл	41,164,930.7	69.3%	30,651,341.7	65.3%	10,513,589.0	34.3%
8.2.Хугацаа хэтэрсэн зээл	1,045,175.5	1.8%	2,691,975.7	5.7%	(1,646,800.2)	-61.2%
8.3.Чанаргүй зээл	3,165,385.6	5.3%	3,848,762.3	8.2%	(683,376.7)	-17.8%
8.3.1. Хэвийн бус	484,405.6	0.8%	1,242,621.2	2.6%	(758,215.5)	-61.0%
8.3.2. Эргэлзээтэй зээл	461,064.7	0.8%	987,249.9	2.1%	(526,185.2)	-53.3%
8.3.3. Муу зээл	2,090,019.2	3.5%	1,618,891.1	3.4%	471,128.1	29.1%
8.4.(Зээлийн эрсдэлийн сан)	2,290,987.4	3.9%	2,562,711.6	5.5%	(271,724.1)	-10.6%
<b>АВЛАГА (ЦЭВРЭЭР)</b>	<b>2,650,407.2</b>	<b>4.5%</b>	<b>2,938,973.0</b>	<b>6.3%</b>	<b>(288,565.8)</b>	<b>-9.8%</b>
9. Байгууллага, хүмүүсээс авах авлага	368,166.8	0.6%	310,667.1	0.7%	57,499.7	18.5%
10. (Байгууллага, хүмүүсээс авах авлагий эрсдэлийн сан)	220,481.6	0.4%	41,730.3	0.1%	178,751.3	428.3%
11. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,502,722.0	4.2%	2,670,036.2	5.7%	(167,314.2)	-6.3%
<b>БУСАД ХӨРӨНГӨ</b>	<b>368,854.1</b>	<b>0.6%</b>	<b>228,236.7</b>	<b>0.5%</b>	<b>140,617.4</b>	<b>61.6%</b>
12. Материал үнэ бүхий зүйл	143,175.3	0.2%	119,353.8	0.3%	23,821.5	20.0%



14. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	155,882.8	0.3%	57,807.5	0.1%	98,075.3	169.7%
15. Бусад актив	69,796.0	0.1%	51,075.3	0.1%	18,720.7	36.7%
<b>ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)</b>	<b>525,247.3</b>	<b>0.9%</b>	<b>784,749.0</b>	<b>1.7%</b>	<b>(259,501.7)</b>	<b>-33.1%</b>
16. Өмчлөх бусад хөрөнгө	559,355.2	0.9%	846,010.8	1.8%	(286,655.6)	-33.9%
17. (Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн сан)	34,107.9	0.1%	61,261.8	0.1%	(27,153.9)	-44.3%
<b>2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	<b>1,340,830.8</b>	<b>2.3%</b>	<b>1,077,485.9</b>	<b>2.3%</b>	<b>263,344.9</b>	<b>24.4%</b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)</b>	<b>1,259,088.7</b>	<b>2.1%</b>	<b>981,806.8</b>	<b>2.1%</b>	<b>277,281.9</b>	<b>28.2%</b>
18. Үндсэн хөрөнгө	1,730,452.1	2.9%	1,426,405.9	3.0%	304,046.2	21.3%
19.( Үндсэн хөрөнгийн элэгдэл)	471,363.4	0.8%	444,599.1	0.9%	26,764.3	6.0%
<b>БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	<b>81,742.1</b>	<b>0.1%</b>	<b>95,679.1</b>	<b>0.2%</b>	<b>(13,936.9)</b>	<b>-14.6%</b>
20. Биет бус хөрөнгө	64,949.9	0.1%	65,543.9	0.1%	(594.0)	-0.9%
21.Бусад	16,792.3	0.0%	30,135.2	0.1%	(13,342.9)	-44.3%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)</b>	<b>59,360,797.6</b>	<b>100.0%</b>	<b>46,938,581.4</b>	<b>100.0%</b>	<b>12,422,216.2</b>	<b>26.8%</b>

Салбарын тайлант улирлын нийт активын бүтцийг гаргавал:



Тайлант улиралд активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12,422,216.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд хадгаламж 10,182,675.9 мянган төгрөгөөр, богино хугацаат зээл 1,164,405.1 мянган төгрөгөөр, хувь нийлүүлсэн хөрөнгө 901,069.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нөлөөлсөн байна.

Активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад мөнгөн хөрөнгө 4,240,489.8 мянган төгрөгөөр, нийт зээл 8,053,516.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зээлийн чанар сайжирсан байна.



Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг графикаар гаргавал:



Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Активын хэмжээ	Хоршоодын тоо	Нийт актив /мянган төгрөгөөр/	Нийт активт эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	26,444,393,9	44.5%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	5	15,750,394,1	26.5%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	7	5,045,222,7	8.5%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	42	8,606,249,8	14.5%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	25	1,764,199,6	3.0%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	66	1,596,588,6	2.7%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	17	127,359,5	0.2%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	7	26,389,4	0.0%
	Нийт дүн	170	59,360,797,6	100.0%

Активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 750,000.0-26,500,000.0 мянган төгрөг хүртэлх активтай нийт 10 хоршооны нийт актив нь 45,518,693.3 мянган төгрөг бөгөөд нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 170 хоршоодын нийт активын 76.7 хувийг эзэлж байна.

#### 4.2 Зээлийн багцын чанар


Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2011.09.30	хувь	2010.09.30	хувь	ӨӨРЧЛӨЛТ	
<b>ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)</b>	<b>42,954,608.3</b>	<b>72.4%</b>	<b>34,629,368.0</b>	<b>77.0%</b>	<b>8,325,240.3</b>	<b>24.0%</b>
Нийт зээл	45,245,595.7	76.1%	37,192,079.6	80.9%	8,053,516.1	21.6%
Хэвийн зээл	41,164,930.7	69.3%	30,651,341.7	73.8%	10,513,589.0	34.3%
Хугацаа хэтэрсэн зээл	1,045,175.5	1.7%	2,691,975.6	2.5%	(1,646,800.1)	-61.2%
Чанаргүй зээл	3,035,489.5	5.1%	3,848,762.2	4.6%	(813,272.7)	-21.1%
<i>Хэвийн бус</i>	<i>484,405.6</i>	<i>0.8%</i>	<i>1,242,621.2</i>	<i>1.3%</i>	<i>(758,215.6)</i>	<i>-61.0%</i>

Эргэлзээтэй зээл	461,064.7	0.8%	987,249.9	1.3%	(526,185.2)	-53.3%
Муу зээл	2,090,019.2	3.5%	1,618,891.1	2.1%	471,128.1	29.1%
(Зээлийн эрсдэлийн сан)	2,290,987.4	3.8%	2,562,711.6	3.9%	(271,724.2)	-10.6%

Зээлийн багцыг графикаар харуулбал:



Тайлант улиралд нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,053,516.1 мянган төгрөгөөр буюу 21.6 хувиар өссөн, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 1,646,800.1 мянган төгрөг буюу 61.2 хувиар, зээлийн эрсдэлийн сан 271,724.2 мянган төгрөг буюу 10.6 хувиар буурсан байна. Энэ нь чанаргүй зээлийн багц 813,272.7 мянган төгрөгөөр буурч, зээлийн багцын чанар сайжирсан хэдий ч муу зээлийн ангилалд 471,128.1 мянган төгрөгийн зээл нэмэгдэж ангилагдсан байна.

Зээлийн болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хэмжээ 2,290,987.4 мянган төгрөг буюу нийт актив хөрөнгийн 3.8 хувийг эзэлж, зээлийн эрсдэлийн сан өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт 271,724.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 464,900.9 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ. (Зээлийн эрсдэлийн санг системийн хэмжээгээр 202,924.3 мянган төгрөгөөр дутуу байгуулсан)

**ТАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**


Хоршоодын тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	2011.09.30		2010.09.30		Өөрчлөлт	
	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь
1. ӨР ТӨЛБӨР	47,344,554.6	79.8%	35,882,512.8	76.4%	11,462,041.8	239.7%
ХАДГАЛАМЖ	42,115,588.1	70.9%	31,932,912.2	68.0%	10,182,675.8	31.9%
1. Хугацаагүй	2,124,614.3	3.6%	1,691,644.6	3.6%	432,969.6	25.6%

*Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 2011 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга*

2. Хугацаатай	39,990,973.8	67.4%	30,241,267.6	64.4%	9,749,706.2	32.2%
<b>БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ</b>	<b>1,807,790.9</b>	<b>3.0%</b>	<b>643,385.8</b>	<b>1.4%</b>	<b>1,164,405.0</b>	<b>181.0%</b>
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	1,715,090.9	2.9%	566,697.5	1.2%	1,148,393.4	202.6%
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	92,700.0	0.2%	76,688.4	0.2%	16,011.6	20.9%
<b>БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,105,346.3</b>	<b>5.2%</b>	<b>3,053,740.8</b>	<b>6.5%</b>	<b>51,605.5</b>	<b>1.7%</b>
5. Татварын төлөх өглөг	79,132.9	0.1%	83,372.0	0.2%	- 4,239.1	-5.1%
6. Хуримтлууулж тооцсон хүүгийн өглөг	2,467,557.7	4.2%	2,000,931.1	4.3%	466,626.5	23.3%
7. Өглөг	528,590.7	0.9%	921,932.0	2.0%	- 393,341.3	-42.7%
8. Бусад пассив	30,065.0	0.1%	47,505.7	0.1%	- 17,440.6	-36.7%
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>315,829.4</b>	<b>0.5%</b>	<b>252,473.9</b>	<b>0.5%</b>	<b>63,355.4</b>	<b>25.1%</b>
8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	272,126.3	0.5%	252,473.9	0.5%	19,652.3	7.8%
9. Урт хугацаат төслийн санхүүжилт	43,703.1		-			
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>12,016,243.0</b>	<b>20.2%</b>	<b>11,056,068.6</b>	<b>23.6%</b>	<b>960,174.4</b>	<b>13.9%</b>
<b>ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>8,192,257.4</b>	<b>13.8%</b>	<b>7,291,187.8</b>	<b>15.5%</b>	<b>901,069.7</b>	<b>12.4%</b>
10. Хувь нийлүүлсэн хөрөнгө	8,192,257.4	13.8%	7,291,187.8	15.5%	901,069.7	12.4%
<b>ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ</b>	<b>3,823,985.6</b>	<b>6.4%</b>	<b>3,764,880.8</b>	<b>8.0%</b>	<b>59,104.7</b>	<b>1.6%</b>
11. Нөөцийн сан	1,770,389.9	3.0%	1,505,068.1	3.2%	265,321.8	17.6%
12. Дахин үнэлгээний сан	267,857.3	0.5%	92,220.6	0.2%	175,636.6	190.5%
13. Нийгмийн хөгжлийн сан	262,780.8	0.4%	198,884.1	0.4%	63,896.7	32.1%
14. Бусад сангууд	116,429.6	0.2%	125,135.4	0.3%	- 8,705.8	-7.0%
15. Хандив, тусламж	61,585.0	0.1%	42,332.0	0.1%	19,252.9	45.5%
16. Бусад өмч	13,090.5	0.0%	53,396.1	0.1%	- 40,305.6	-75.5%
17. Тайлангийн үеийн ашиг/алдагдал	1,028,275.9	1.7%	563,374.9	1.2%	464,901.0	82.5%
18. Хуримтлагдсан ашиг/алдагдал	303,576.6	0.5%	1,184,469.6	2.5%	- 880,892.9	-74.4%
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)</b>	<b>59,360,797.6</b>	<b>100.0%</b>	<b>46,938,581.4</b>	<b>100.0%</b>	<b>12,422,216.2</b>	<b>253.6%</b>

Салбарын тайлант улирлын нийт пассивын бүтцийг гаргавал:



Тайлант улиралд гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10,182,675.8 мянган төгрөгөөр буюу 31.9 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгө 901,069.7 мянган төгрөг буюу 12.4 хувиар, хоршоологчдын өмч 59,104.7 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар тус тус өссөн байна. Хоршоологчдын өмчийн өсөлтөд нөөцийн сангийн хэмжээ 265,321.8 мянган төгрөгөөр, дахин үнэлгээний сан 175,636.6 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хоршоодын гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг бүлэглэн харуулбал:

д/д	Хадгаламжийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт хадгаламжийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	20,563,913.6	48.8
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	4	12,540,884.3	29.8
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	4	2,637,836.9	6.3
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	18	3,990,521.3	9.5
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	16	1,152,614.4	2.7
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	46	1,020,227.6	2.4
7	1,000.0-10,000.0 мянган төгрөг	40	201,496.0	0.5
8	1,000.0 мянган төгрөг хүртэл	17	8,093.9	0.0
9	Хадгаламжгүй	24	-	-
	Нийт дүн	170	42,115,588.1	100.00%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй нийт 9 хоршооны хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ 35,742,634.8 мянган төгрөг нь хоршоодын нийт хадгаламжийн үлдэгдлийн 84.9 хувийг эзэлж байна.

Хадгаламж татан төвлөрүүлээгүй нийт 24 хоршоо байгаа бөгөөд нийт хоршоодын 14.1 хувийг эзэлж, зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.

Номин юнион хоршооны татсан хадгаламж 20.5 тэрбум төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хадгаламжийн 48.7 хувийг эзэлж байна.

Хувь нийлүүлсэн хөрөнгө тайлант улиралд 8,192,257.4 мянган төгрөг байгаа бөгөөд бүлэглэж харуулбал:

д/д	ХНХ-ийн үзүүлэлт	Хоршооны тоо	ХНХ-ийн хэмжээ /мянган төгрөгөөр/	Нийт ХНХ-ийн хэмжээнд эзлэх хувь
1	2,000,000.0 мянган төгрөгөөс дээш	3	3,273,651.9	40.0
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	7	1,296,255.7	15.8
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	19	1,339,614.7	16.4
4	15,000.0-50,000.0 мянган төгрөг	58	1,652,159.0	20.2
5	10,000.0-15,000.0 мянган төгрөг	26	320,624.0	3.9
6	5,000.0-10,000.0 мянган төгрөг	29	215,010.3	2.6
7	1,000.0-5,000.0 мянган төгрөг	28	94,941.8	1.2
	Нийт дүн	170	8,192,257.4	100.0

Харин хадгаламж, зээлийн хоршоодын хоршоологчдын өмч 3,823,985.6 мянган төгрөг байгаа бөгөөд интервалаар харуулбал:

д/д	ХНХ-ийн үзүүлэлт	Хоршооны тоо	Хоршоологчдын өмчийн дүн /мянган төгрөгөөр	Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь
1	500,000.0-2,000,000.0 мянган төгрөг	1	760,920.6	19.9
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	8	2,069,902.4	54.1
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	10	696,761.0	18.2
4	15,000.0-50,000.0 мянган төгрөг	26	726,886.8	19.0
5	10,000.0-15,000.0 мянган төгрөг хүртэл	17	201,048.9	5.3
6	1,000.0-10,000.0 мянган төгрөг	66	275,877.8	7.2
7	1,0-1,000.0 мянган төгрөг	16	7,312.3	0.2
8	Хоршоологчдын өмчгүй <sup>3</sup> /алдагдалтай/	26	-914,724.2	- 23.9
	Нийт дүн	170	3,823,985.6	100.0%

### ЗУРГАА. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭСЭН ТАЛААР

Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй хоршоодыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээгээр нь 4 ангилж дараах байдлаар бүлэглэсэн. Үүнд:

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах хоршоодын тоо	Хоршоодын тоонд эзлэх хувь	Нийт активт эзлэх хувь	Үүнээс	
					УБ хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо
Бүлэг-1	50.0 сая төгрөг хүртэл	90	53.0%	2,9%	32	58
Бүлэг-2	50-500.0 сая төгрөг	68	40.0%	18,8%	31	37
Бүлэг-3	500.0-1.0 тэрбум төгрөг	7	4.1%	8,5%	5	2
Бүлэг-4	1.0 тэрбумаас дээш	5	2.9%	69,8%	5	-
Нийт дүн		170	100.0%	100%	73	97

### ДОЛОО. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

<sup>3</sup> Иргэний хуулийн 36.4-д “Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бэхий дундын эд хөрөнгө дээр индэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.”

	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛАНГААР	
<b>А</b>	<b>АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН</b>		
1	АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, - дутуу) /мянган төгрөгөөр/	2,493,911.7	<b>2,290,987.4</b> дутуу байгуулсан
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	<b>6.7%</b> хангаагүй
3	ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (30 хувиас доош)	30.0%	0.0%
<b>Б</b>	<b>ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>		
4	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (50-80 хүртэлх хувь)	50%-80%	72.4%
5	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	0.9%
6	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0%	2.1%
7	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 хүртэлх хувь)	80.0%	70.9%
8	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)	10.0%	3.3%
9	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	13.8%
10	ГИШҮҮДИЙН ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас дээш)	10.0%	<b>6.4%</b> хангаагүй
11	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	573,597,833.8	1,770,389,929.9
<b>В</b>	<b>ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ</b>		
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (5 хувиас бага)	5.0%	3.1%
<b>Г</b>	<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР</b>		
14	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	11.4%
<b>Д</b>	<b>ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)</b>		
15	АКТИВЫН ӨГӨӨЖ		2.3%
16	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ		15.4%
17	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		20.3%

Хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлээс харахад чанаргүй зээлийн зохистой харьцаа 5.0 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарласан боловч нийт салбарын хувьд 1.7 хувиар хэтрүүлсэн, активын эрсдэлийн санг 202.924.3 мянган төгрөгөөр дутуу байгуулсан, гишүүдийн хоршоологчдын өмчийн харьцаа нийт активын 10.0 хувиас дээш байхаар заасан боловч 3.6 хувиар дутуу зэрэг зөрчилтэй байна.

Чанаргүй зээлийн багц өмнөх оны мөн үеээс 813,272.7 мянган төгрөгөөр буурч, зээлийн багцын чанар сайжирсан хэдий ч муу зээлийн ангилалд 471,128.1 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдэж ангилагдсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн зохистой харьцааны хангаагүй хувь 0.8 хувиар, гишүүдийн хоршоологчдын өмчийн хангаагүй хувь 0,6 хувиар тус тус буурсан байна. Харин бусад шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна.

## НАЙМ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Тайлант улиралд нийт 170 хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хоршоодоос Улаанбаатар хотод 73 хоршоо, орон нутагт 97 хоршоо үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийт 170 хоршоо 2011 оны гуравдугаар улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг Хороонд ирүүлэх ёстойгоос 2011 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар нийт 149 хоршоо тайлангаа ирүүлсэн нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын 87,6 хувь байгаа бөгөөд хоршоо хариуцсан хянан шалгагчид ирүүлсэн тайлангуудыг хянаж, бүгд 149 хоршоонд тайлангийн хариуг өгч, зохистой харьцаа хангаж ажиллаагүй хоршоодод хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн байна.

Санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг хугацаанд нь ирүүлсэн 67 хоршоо буюу нийт хоршоодын 39,4 хувийг, хугацаа хоцроосон 82 хоршоо буюу нийт хоршоодын 48,2 хувийг, огт ирүүлээгүй 21 хоршоо буюу нийт хоршоодын 12,3 хувийг тус тус эзэлж байна.

Гуравдугаар улирлын байдлаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн гол үзүүлэлтийг банкны салбарын мөн үзүүлэлттэй харьцуулахад нийт актив 0.9 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 1.2 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 0.8 хувь, татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл 1.4 хувийг тус тус эзэлж байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос 2011 оны зохицуулалт үйлчилгээний хөлс 13,030.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс 2011 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 12,773.9 мянган төгрөг буюу 98.0 хувийг төсөвт төвлөрүүлсэн, бөгөөд нэг удаа төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлснөөс тусгай зөвшөөрлийн сунгалтын хураамж болох нийт 220,0 мянган төгрөг төлөхөөс 70,0 мянган төгрөг төлөгдсөн байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа системийн хувьд 11.4 хувьтай байгаа нь Хорооноос тогтоосон зохистой харьцааг хангаж байна.

Гишүүдээс татсан хадгаламж, олгосон зээлийн хэмжээг 2007-2011 оны гуравдугаар улирал хүртэлх байдлаар харуулбал:





Хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдээсээ татан төвлөрүүлсэн хадгаламж болон олгосон зээлийн хэмжээ өсөлттэй байгаа бөгөөд 2011 оны гуравдугаар улиралд татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл 42.1 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын 1.4 хувийг, зээлийн өрийн үлдэгдэл 45.2 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.2 хувийг тус тус эзэлж байна.

## БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР